**МОНГОЛ УЛС**
**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 20 өдөр          Дугаар А/585          Хэрлэн сум

Шинжилгээ хийх, бүтэц, орон тоог шинэчлэн батлуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны 469 дүгээр тогтоол, 2023 оны 378 дугаар тогтоол, Засгийн газрын "Аргачлал батлах тухай" 2018 оны 22 дугаар тогтоолыгыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засгийн газраас аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарт өөрчлөлт орсонтой холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын чиг үүрэгт шинжилгээ хийх, бүтэц, орон тоог шинэчлэн батлуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Ж.Гантулга | Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга |
| Нарийн бичгийн дарга: | Ш.Эрдэнэжаргал | Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн |
| Гишүүд: | Ч.Баярцолмон | Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга |
| | Б.Дарханбаатар | Хууль, эрх зүйн хэлтсийн дарга |
| | Э.Мөнх-Эрдэнэ | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга |
| | С.Нямдаваа | Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга |
| | Ц.Ганчимэг | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга |
| | Н.Зоригтбаатар | Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч |

2.Батлагдсан аргачлалын дагуу аймгийн Засаг даргын тамгын газрын чиг үүргийн шинжилгээг хийж, аймгийн Засаг даргын тамгын газрын хэлтэс, тасаг хоорондын чиг үүргийн давхардал, хийдэл үүсгэхгүйгээр оновчтой зохицуулалт хийж ажиллахыг Ажлын хэсэг (Ж.Гантулга)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА          Ц.ЧОГСОМЖАВ

D:\My Documents_Захирамж-2023

2310123 64